



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/600

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Грийн фантом" ХХК-ний гүйцэтгэсэн Ховд аймгийн Дөргөн суманд цөлжилт газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Л.Батбаяр

- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Гишүүд: Д.Бөхболд

- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
ойн асуудал хариуцсан мэргэжилтэн

Э.Хосбаяр

- Сум дундын ойн ангийн мэргэжилтэн

Д.Буянтогтох

- Дөргөн сумын байгаль хамгаалагч

Б.Түмэнжаргал

- Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Б.Баттулга

- "Грийн фантом" ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Х.Баасанхүү

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Ховд аймгийн Дөргөн суманд цөлжилт газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах ажлыг захиалагчаас баталсан ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Л.Батбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН